

ХҮНИЙ БИЕ МАХБОДТОЙ ХОЛБООТОЙ ЦӨӨН ҮГИЙГ АЛТАЙ ХЭЛНИЙ ХҮРЭЭНД ХАРЬЦУУЛАН ШИНЖИХ НЬ

Ариц *

Агуулгын товч: Тус өгүүлэлд «Монголын нууц товчоон» дахь “эх” гэсэн үгээс үндэс авч эртний монгол хэл, орчин цагийн монгол хэл, монгол төрөл хэлүүд жич Алтай овгийн хэлэнд багтах Манж, Түрэг, Солонгос хэлний жишээ баримтад тулгуурлан харгалзсан авиа, хэлбэр, утгатай үгсийг харьцуулж улмаар “эх”, “адаг”, “толгой”, “гар”, “хөл” зэрэг үгсийн эртний болоод өдгөөгийн хувирал өөрчлөлтийн тухай баримт нотолгоотой саналыг дэвшүүлж байна.

Түлхүүр үг: эх, адаг, толгой, гар, хөл.

1. "Эх", "Адаг" хэмээх үгийн учир

«Монголын нууц товчоон»¹ (цаашид МНТ гэж товчилно)-д хүний толгойг заах “эх” гэсэн үг байдаг. Уг хэлбэр нь “额乞”, олон тооны хэлбэр нь “额乞惕” ба үгийн эхний h гийгүүлэгч “赫乞” хэлбэрээр нийт 4 удаа тохиолдоно. Жишээлбэл:

中合舌 闌歹 因 可兀惕 不荅安 中忽惕 中忽刺 中忽 额乞 帖舌里兀 兀格温 秃刺 不荅阿惕 幹亨黑

壇 帖迭 亨魯罷。 (§46)

* БНХАУ-ын Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургууль

¹ Тус өгүүлэл дэх МНТ-ы эх сурвалжийн хятад галигийг Элдэнтэй, Ардажав (2006), «Монголын нууц товчоон» - харгуулан хянасан дэвтэр /蒙古秘史校勘本/-ээс эшлэв. Латин галигийг Т. Дашцэдэн (2006), «Монголын нууц товчоон» эх бичгийн латин галигаас эшлэв.

(Qaralday-yin kö[b]üüd budaan qudqulaqu eki teriü ügeün tula Budaad oboγtan tede bolba)
(Харандайн хөвгүүд будаан хутгалдах эх тэргүү үггүйн² тул будаад овогтон тэд болов.)

.....客卜帖兀勒 雪泥 幹舌羅中渾 中合舌刺泥 額乞惕 阿訥 荅勒巴舌魯。 (§229)

(...kebteül söni oroqun haran-i ekid anu dalbaru)
(...Хэвтүүл шөнө орхун араныг эхэд нь далбаж)

赫乞 亦訥 你刊帖 迭列都額惕 癸走周 幹難 訥 屯 朵脱舌刺 客卜帖額速 兀者克迭古 客額周。

□ (§81) □

(heki inu nigente deledüed güyijü Onan-nu tün dotor-a kebte[b]esü üjegdekü ke[m]ejü)
(Хэх <Эх> нь нэгэнт дэлдээд гүйж Ононы түнх дотор хэвтвээс үзэгдэх хэмээж)

Нэгдүгээр жишээнд байгаа “эх”-н хятад орчуулга нь “腦” байна. Хоёрдугаар жишээний

“эхэд”-ийн хятад орчуулга “腦每” нь мөнөөх “эх”-ийн олон тоо болохыг харуулна.

Гуравдугаар жишээний “хэх”-ийн хажуугийн орчуулга нь “头項” гэж бий. Элдэнтэй,

Ардажавын « <Монголын нууц товчоон> сийрүүлэл тайлбар»-т “эх тэргүү үгэгүн: эх хэмээх нь толгой түрүүг заана. Дагур хэлэнд “heki” хэмээх нь мөн ч толгой түрүүг заав. Үгэгүн хэмээх нь үгэгүгийн олон тоо. Эх тэргүү үгэгүн хэмээх нь сэтгэхүйн чадвараар муухан гэсэн утга буюу”³ гэж тайлбарлажээ. Бас «Мухамид Ал-Адаб» толинд ч “hyкуну(эх ину), hyкунâr(эхнээр), hyкунw/h, укунw(эхний)” гэхчлэн үгийн эхэнд h гийгүүлэгчтэй хэвээр нь тэмдэглэж буй⁴. Одоо Буриадад ч хүний толгойг “эхин” гэж, мал амьтны толгойг “толгой” гэж нэрлэдэг. Иймээс “эх” гэдэг үг нь эрт үед хүний толгойг заасан утгаар хэрэглэж байсан бөгөөд үгийн эхэндээ h гийгүүлэгчтэй байжээ. Харин МНТ-ы үед энэ h гийгүүлэгч нь сугарах шилжилтийн явцдаа байсан бололтой.

Энэ үгийн тухай Н.Поппе манж хэлний магнайг заасан “fehi” үсэгтэй холбон : 蒙 ekin,

² Ш.Чоймаа (2011), Монголын нууц товчоон эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, Улаанбаатар, 20-р тал.

³ Элдэнтэй, Ардажав (1985), «Монголын нууц товчоон»-сийрүүлэл тайлбар. дээд боть. Өвөр монгол, 69-р тал.

⁴ 王音色巴雅尔 (2012), <穆卡迪玛特阿勒—阿达布>词典蒙古语研究[D]. 中央民族大学.

中蒙 hekin < *pekin “头, 开头”= 满 fehi < *peki(n)“脑”, 果 peje < *pegi < *peki“额”⁵

хэмээн зүйчлэн мөрдсөн байна. Тухайлбал “эх” нь eki < heki < *peki-гийн хувиралыг дамжсан гэж үзүүштэй.

Сүүлийн сурвалж бичгүүдэд “эх” гэсэн үгийн тухай тэмдэглэснээс жишээлбэл: Лувсанданзаны «Алтан товч» дахь МНТ-тай харгуулсан хэсэгт “Хэвтүүл шөнө орхун араныг эхэд ану талбируу” гэж адилхан өгүүлбэрт “эхэд” гэх олон тооны хэлбэрээр илэрсэн ба “эхин мину дэр шиг, элэг мину хал шиг, сүүж мину дэвсгэр шиг болбай”⁶ гэсэн өгүүлбэрт бас хүний толгойг заах утгаар хэрэглэжээ. “Тэр хялбар хүүхэд хүнийг гинж бугуйгаараа эхнийг ину дэлдээд” («Эрдэнийн товч»), “эмгэн өнгө чинь хөгшрөв үү, эхин дэх эвэр ану хувиржан буюу.” (« Гэсэрийн тууж»), “зааны эхин мөн дээр нь хагалюу” («Эрдэнийн сан субашид») гэх мэтчлэн эхний h гийгүүлэгч нь бүрмөсөн сугарч “эхин” гэсэн хэлбэрээр тогтвортой тэмдэглэжээ.⁷

Орчин цагийн Монгол хэлний ууган тайлбар толь гэгддэг «Хорин нэгт тайлбар толь»-д гагцхүү “усны уг гарсан газрыг эх хэмээмүй”⁸ гэсэн утгыг тайлбарлажээ. Цэцэнцогт багшийн «Монгол үгсийн язгуурын толь»-д “эх”/eki/ гэсэн үгийг “эх”/heki/-

ээс үүсэлтэй гэж үзсэн бөгөөд “эхі~хэхі 头, 起初, 起源, 首位 ф <хуучин үг> толгой,

орой. Дагуурт мөн ингэж хэрэглэж байна. 2. Хэрэг юмны эх үүсэл. 3. Түрүү, дээд, ахлагч, анх” гэж тайлбарласан байна.⁹ Орчин цагийн нийт монгол хэлэнд “эх” гэдэг үг нь “голын эх, усны эх, эх булаг” зэрэг урсгал усны угийг заасан ба хэрэг юмны үүслийг заасан утгаар хэрэглэхээс гадна “жилийн эхэн, эхний хүн/тоглолт” зэргээр түрүүний, анхны, нэгдүгээр гэх мэтийн сүүлд шиг салбарлаж гарсан утгаар хэвшиж уугуул утга нь мартагдсан байна. Энэ үгээр язгуур болсон “эхлэлт, эхлэл, эхлэх” зэрэг үгс нь маш идэвхтэй хэрэглэсээр байна.

Дээр дурдсанчлан Монгол хэлэнд хүний биеийн дээр үзүүр - толгойг зааж байсан “эх” нь мөн усны уг гарсан газрыг хэлдэг бол эсрэг утгатай болох урсгал усны доод урсгал, эцэс төгсгөлийн хэсгийг нь “адаг” хэмээдэг. Мөн “голын адаг, усны адаг” гэх мэтээр хэрэглэдэг. Орчин цагийн монгол хэлэнд ч “эх адаг” хэмээх үгийг холбоо үгийн хэлбэрээр хоршиж хэрэглэдэг. Түрэг төрөл хэлний Уйгар, Казак, Кергиз, Үзбек, Татар

⁵ (美) 鲍培著 (2003), 周建奇译 阿尔泰语比较语法[M]. 呼和浩特: 内蒙古教育出版社: 162.

⁶ Б.Ванжил (2006), Хөх түлхүүр-эртний монгол хэлний үгсийн тайлбар. Өвөр монгол, 80-р тал.

⁷ Цэцэнцогт (1988), Монгол үгсийн язгуурын толь, Өвөр монгол, 194-р тал.

⁸ Өвөр монголын монгол хэл, утга зохиол, түүх судлах газар (1979), Хорин нэгт тайлбар толь. Өвөр монгол. 52-р тал.

⁹ Цэцэнцогт (1988), Монгол үгсийн язгуурын толь. Өвөр монгол. 193-194-р тал.

зэрэг хэлэнд “ajaq”., Салаа¹⁰ хэлэнд “ajaq” ., Баруун ёгор хэлэнд “azaq” гэж тус тус хүний биеийн хамаг доор үзүүр болох хөлийг нэрлэдэг (орчин цагийн уйгар хэлэнд “ajaq” гэж шаахайг бас хэлдэг). Түрэг төрөл хэлний “j” авиа нь ихэнхдээ монгол хэлний “d” авиатай тохирдог. Монгол хэлний дэл del < эртний түрэг хэлний jil ; jël., Монгол хэлний дэлэн deleŋ < Күман хэлэнд jälin, Башкир хэлэнд jëlän., Монгол хэлний долоо doluγa < эртний Түрэг хэлэнд jalγa-/ jalqa- зэрэг олон жишээгээр батлагдана.¹¹ Иймээс Түрэг төрөл хэлний “ajaq” нь Монгол хэлний “adaγ” /адаг/ -тай тохиролцож буй. Бас Солонгос хэлэнд “padak” гэж “хөлийн ул, шал, ёроол” гэсэн утгатай үг байна¹². Энэ бүхнийг нэгтгэвэл Монгол хэлний adaγ < *padāk (эцэс сүүл, гол мөрний доод урсгал) = Солонгос хэлний padak (хөлийн ул, ёроол) = эртний Түрэг хэлэнд ajaq < *padāk хэмээх үгсийг гарал нэгтэй “хөл” хэмээх утгатай гэж үзэж болно¹³.

Ийнхүү орчин цагийн монгол хэлэнд усны доод урсгал буюу хэрэг учрын эцэс төгсгөл гэх утгатай бөгөөд хүн юмны хамаг муу, доод зэргийг илтгэсэн салбар утгатай “адаг (adaγ < *padāk)” гэсэн үг нь анхандаа хүний доод хоёр мөчийг зааж байсан бололтой. Энэ нь түрэг төрөл хэлтэнд уул утгаа хадгалж үлдсэн байна.

2. "Хөл", "Толгой" хэмээх үгийн учир

Орчин цагийн монгол хэлэнд хүний доод хоёр мөчийг “хөл” гэдэг. Монгол төрөл хэлэнд “хөл”-тэй тохиролцох: нийт Монгол хэлэнд “xol”, Дагур хэлэнд “kuli”, Зүүн ёгор хэлэнд “køl”, Монгол хэлэнд “kol”, Дунсян хэлэнд “kon”, Баоан хэлэнд “kuol”, Канжиа¹⁴ хэлэнд “kuar~kor” гэх хэлбэртэй¹⁵.

“Хөл” гэсэн үг нь МНТ-д “闊楊, 闊勒, 可里(耶舌兒), 闊里(顏)” гэх хэлбэртэйгээр нийт

17 удаа илэрнэ. Хажуугийн орчуулга нь бүр “脚”. Үүнд “闊勒” бол “хөл”-тэй

тохиролцох уул хэлбэр, “闊楊” нь хоёр гэсэн тооны ард орсон орчинд илэрсэн болохоор

“хөл”-ийн олон тооны хэлбэр байж таарна. Гэвч Элдэндэй, Ардажавын харгуулан

¹⁰ Түрэг төрөл хэлэнд багтана, голдуу БНХУ-д амьдарч байгаа Салаа үндэстэний хэрэглэж буй хэл.

¹¹ (美) 鲍培著(2003), 周建奇译.阿尔泰语比较语法[M].呼和浩特: 内蒙古教育出版社: 25.

¹² (美) 鲍培著(2003), 周建奇译.阿尔泰语比较语法[M].呼和浩特: 内蒙古教育出版社: 62.

¹³ (美) 鲍培著(2003), 周建奇译.阿尔泰语比较语法[M].呼和浩特: 内蒙古教育出版社: 146.

¹⁴ Цэцэнцогт 1999 онд хэвлүүлсэн «Канжиа хэлний судлал»/《康家语研究》/ номдоо БНХАУ-ын Хөхнуур мужын Жанжа шяны/尖扎县/ Канян хотод/康杨镇/ амьдарч байгаа хэсэг хотон хүмүүсийн хэрэглэж буй Канжиа хэлийг Монгол төрөл хэлэнд багтах биеэ даасан хэл хэмээх санал дэвшүүлжээ.

¹⁵ 德力格尔玛(2006), 波苏德著.蒙古语族语言概论[M].北京: 中央民族大学出版社: 96.

хянасан дэвтэрт “闊^(楊)[勒]”¹⁶ гэдгийг “闊勒” болгон зассан бөгөөд Баярын галигласан дэвтэрт ч шууд “闊勒”¹⁷ болгон засан бичжээ. “可里(耶^舌兒), 闊里(顏)” бол ард нь дагавар дагалдах үеийн хувилбар болно. Жишээлбэл:

.....中豁牙兒 闊^(楊)[勒] 亦訥 扯兒別格勒者溫勒周 中合荅^舌刺周 古兒抽 亦^舌列額^[勒]。

(§101)□

(...qoyar köd inu čerbegeljeüljü qataraju kürcü ireed.)

(...Хоёр көт <хөл> ину цэрбэлзүүлж хатирч хүрч ирээд.)

中豁亦圖 農中合速禿 帖兒干 圖兒 兀訥周 阿馬撒^舌刺 不恢 農中合速 塔塔刺周 闊勒 圖

兒 古兒恢突兒 鎖兒中罕失^舌刺 (§86) □

(qoyitu nungyasutu tergen-dür unuju amasar-a бүкүй nungyasu tatalaju köl-dür kürküydur Sorqan sir-a...)

(Хойт нунгаст тэргэнд нь унаж амсар бүхий нунгас татлаж хөлд хүрэхүйд сорхон шар...)

Ийнхүү МНТ-д нэгэнт хүн амьтны доод хоёр мөчийг заах –“хөл” гэсэн үгийг хэрэглэж байсан нь тодорхой байна. Гэвч одоогийн Уйгар, Казак, Киргиз, Үзбек, Татар зэрэг Түрэг төрөл хэлэнд “qol” гэж дээд хоёр мөчийг заах утгатай үгээр хэрэглэж байгаа нь бидний сонирхлыг татаж байна. Тува хэлэнд “xol” гэж бас хүний дээд хоёр мөчийг нэрлэсэн үг байх, Баруун ёгор хэлэнд “Gol” гэж гарын ар тал буюу бугуй тохойг заах үг байгаа бол Салаа хэлэнд “Gol” гэж бугуй тохойг заах үг тус тус байна.

Үүнээс гадна МНТ-д “хөл”-тэй эсрэгцэлдэх хүний дээд хоёр мөчийг заах “гар” гэсэн үг “中合兒, 中合^舌兒, 中合^舌里, 中合^舌侖, 中合^舌刺(察)” гэх хэлбэртэйгээр 47 удаа илэрнэ. Хажуугийн орчуулга нь “手”. “中合兒, 中合^舌兒, 中合^舌里” нь “гар” гэх уул хэлбэртэй тохиролцож “中合^舌侖” нь “гар +ын = гарун” хэлбэр, “中合^舌刺(察)” бол ардаа гарахын тийн ялгалын нөхцөлийг тэмдэглэсэн хувилбар болно. Жишээ нь:

¹⁶ Элдэнтэй, Ардажав (1985), « Монголын нууц товчоон » - сийрүүлэл тайлбар, дээд боть. Өвөр монгол, 138-р тал.

¹⁷ Баяр (1980), Монголын нууц товчоон, галиг, тэргүүн боть, Өвөр монгол, 233-р тал.

額朵額 額捏 升_中豁兒 阿_楊忽周 阿_卜赤_舌刺周 中合兒 圖兒 米訥 禿兀罷。 □ (§63)

(Edöge ene šingqor adquju abčiraju γar-tur minu tuuba.)

(Эдүгээ энэ шонхор атгаж авч ирж гар дор минь туув.)


中合_舌里顏 額_卜徹溫都_舌里顏 抹額列_楊抽。納_舌蘭 竹克 也孫帖 莎葛_楊抽 撒出里 幹赤

兀里 幹_克罷。 (§103)

(γar-iyān ebčēün-dür-iyen möele/d/čü naran jük yisūnte sөгөdčü sačuli öčiüli ö/g/be.)

(Гараан өвчүүн дороо мөгэлэтчү, наран зүг есөнтөө сөгдөж цацал үзүүл өгөв.)

Ийнхүү МНТ-д маш идэвхтэй хэрэглэгддэг “гар” гэсэн үг нь хүний дээд хоёр мөчийг заасан утгатай байжээ. Монгол төрөл хэлнүүдэд: орчин цагийн Монгол хэлэнд “gar”, Дагур хэлэнд “gari”, Зүүн ёгор хэлэнд “Gar”, Монгол хэлэнд “Gar”, Дунсян хэлэнд “qa”, Бао ан хэлэнд “χαr”, Канжиа хэлэнд “χαr” гэх харгалзах хэлбэрүүд байна¹⁸. Солонгос хэлэнд “karak” гэж хурууг илтгэсэн утгатай үг. Энэ нь урьд дээд хоёр мөчийг илтгэж байсан “kara” гэсэн үгнээс үүсэлтэй.¹⁹ Манж тунгүс төрөл хэлний Манж хэлэнд “gala”, Шивээ хэлэнд “Gal”, Орчон хэлэнд “ηaala”, Эвэнки хэлэнд “naalla”, Хэжэ хэлэнд “nala” гэж тус тус тохиролцсон хэлбэртэй. Үүнийг өмнө дурдсан Түрэг төрөл хэлүүдийн “qol~hol~Gol” зэрэг адилхан дээд хоёр мөчийг заах үгстэй холбон бодвол, эдгээр үгс нь цөм ижил гаралтай хэмээн үзэж болно. Хүний дээд хоёр мөчийг илтгэж байгаа үгсийг зургаар бүдүүвчлэн үзүүлбэл доорхи мэт:



¹⁸ 德力格尔玛(2006), 波·苏德著. 蒙古语族语言概论[M]. 北京: 中央民族大学出版社: 96.

¹⁹ 吴双(2014), 满语人体词语语义研究[D]. 黑龙江大学.

Үүнээс үзвэл “хөл (<*kolö)” нь нийт Алтай хэлэнд хүний дээд хоёр мөчийг заасан утгатай байсан бололтой. Тэгвэл ягаад Түрэг төрөл хэл ба Солонгос хэлэнд “хөл” нь бас угийн утгаа хадгалж байхад Монгол төрөл хэлтэнд “хөл” нь доод хоёр мөчийг заах болж “гар” гэх үгээр дээд хоёр мөчийг заах болсон вэ? гэвэл бүр эрт үед “хөл (<*kolö)”-ээр дөрвөн мөчийг цөм зааж болох байсан бөгөөд сүүлд нь дээд доод мөчийн ялгаа зөрөө улмаар ихэссэнээс шалтгаалан Монгол төрөл хэлэнд “хөл (<*kolö)”-өөс “гар” гэх үг үүсч дээд мөчийг заах болж “хөл” нь тусгай доод мөчийг нэрлэдэг болжээ гэхэд болох юм. Харин бусад төрөл хэлнүүдэд “хөл” болоод түүнээс үүсэлтэй үгс нь мөнөөх дээд хоёр мөчийг заах утгаараа байгаа бөгөөд “адаг”-тай тохиролцох “ajaq(<*padàk)”-аар доод хоёр мөчийг тусгайлан заах болжээ. Орчин цагийн Монгол хэлэнд “хөл” нь нэгэнт хүн амьтны доод хоёр мөчийг илтгэхээс гадна юмны үндэс суурь тулгуурыг илтгэх үгийн сангийн салбар утгатай болж “ширээний хөл, тогооны хөл, шатарын хөл, гүүрний хөл” гэх мэтчилэн холбоо үгээр хэрэглэдэг. Бас утга хийсвэржиж “хөл алдах, хөл хүнд, хөл хорих, хөл орох, хөл үймээн”²⁰ зэрэг холбоо хоршоо үгийг бүтээдэг.

Харин үүнтэй холбон бидний анхаарлыг татаж буй нэгэн жишээ бол эртний Түрэг хэлэнд “qol” гэж нуур гэсэн утгатай үг байна. Эрдэмтэд байгал (бай+гөл), хөвсгөл (хөвс+гөл), хөлөн(хөл+н) зэрэг нуурын нэрэнд байх “гөл/хөл”-ийг Түрэг хэлний “qol”-тай нэг үг гэж үздэг. Мэдээжээр нуур бол хуурай газраар хүрээлэгдсэн ихээхэн талбайтай гүн хурмал тогтсон ус. Үүний эх үндэс нь гэвэл хур бороон элбэгээс хурж бүрэлдэх, ихээхэн гол мөрний урсгал дуусах хэсэгт тунаж тогтох, цаст уулаас хайлж урссан ус нь тунаж тогтон бүрэлддэг. Даруй урсгал усны адаг нь нуур юм. Монгол хэлэнд бас “усны хөл, хөлгүй гүн ус, хөлгүй ус” гэж усны шувтарга адаг буюу ёроолыг заасан холбоо үг байдаг. Тэгэхээр Түрэг хэлэнд нуур - урсгал усны эцэс төгсгөл болох газрыг заах утгатай “qol” гэх үг нь Монгол хэлэнд хүний махбодын доор үзүүрийг заах “хөл”-тэй утга гарлаараа холбогдоно гэж бодож байна.

Үүнээс гадна урсгал усны эх авах газар бол фтэнгэр /бороо хур/, 2далай тэнгис, 3 уулын орой - толгой болно. Энэхүү “толгой” гэх үг нь юмны орой буюу дээд үзүүрийг заах утгатай байсан бөгөөд уул хайрхантай холбоотой үг байсан бололтой. Одоо ч “уулын толгой, ханын толгой, чийдэнгийн толгой, өвсний толгой, уурганы толгой, гансны толгой”²¹ гэж хэрэглэж байх бөгөөд “хоёр толгойн хооронд” гэвэл тасархай дов толгойдыг заах утгатай²². Монгол орон дахь уулын нэр ч “бор толгой, эрдэнэ толгой, оюу толгой” гэж олон байдаг. Харин тус өгүүллийн эхинд өгүүлснээр хүний бие махбодын дээд үзүүрийг “эх” буюу “тэргүүн” гэдэг байжээ. Хожмын үед “толгой” нь

²⁰ Я.Цэвэл (2013), Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар. 971-972-р тал.

²¹ Я.Цэвэл (2013), Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 740-р тал.

²² Цэцэнцогт (1988), Монгол үгсийн язуурын толь, Өвөр монгол. 193-194-р тал.

утга шилжин “эх” гэх үгийг орлон хүний биеийн дээд үзүүр болох хэсгийг нэрлэн хэрэглэж байна. “Тэргүүн” нь мөнөөх хүний биеийн дээд үзүүрийг заах утгаа алдаагүй боловч одоо цагт хүндэтгэлийн өнгө аястайгаар онцгой орчинд хэрэглэх болсон бөгөөд “толгойлогч, удирдагч, ерөнхийлөгч” ба “нэгдүгээр, анхдугаар, анхны, эхний” гэх зэрэг салбар утгатай болжээ. “Тэргүүн захас, тэргүүн сайд, тэргүүн боть, тэргүүн дэвтэр” гэж хэрэглэж байна.²³

Дүгнэлт

Энэ бүхнийг нэгтгэн үзвэл монгол хэлний “эх” (eki<heki<*peki) гэж хүний толгойг заасан утгатай үг нь гол мөрний дээд урсгал буюу эх булгийг заах болж, хожим нь хэрэг юмны үүсэл, анхны, түрүүний, нэгдүгээр гэсэн салаа утгатай болжээ. “Адаг(<*padāk)” гэж хүний бие махбодын доод хоёр мөчийг заах утгатай байсан ба энэ үг нь одоо Түрэг төрөл хэлэнд “ајақ~ајах~азақ” гэх тохиролцсон хэлбэрээр үлджээ. Энэ үг нь мөн урсгал усны доод хэсэг буюу эцэс төгсгөлийн хэсгийг заах болсон бөгөөд одоо хэрэг юмны доод зэргийн, хамгийн адаг муут илтгэх салбар утгатай болжээ.

Харин урсгал усны эх авдаг газрыг нэрлэх – “(уулын) толгой” нь орчин үед хүний бие махбодын дээд орой болох хэсгийг заах болж “эх”-ийг орлосон байна. Адилхнаар урсгал усны эцэст тунаж тогтсон хэсэг болох нуурыг заах – “хөл” нь хүний бие махбодын доод үзүүр болох дөрвөн мөчийг заах болж, одоо болтол Түрэг төрөл хэлэнд багтах хэлнүүд ба Солонгос хэлэнд голдуу хүний дээд хоёр мөчийг заах утгаараа хэрэглэж байна. Харин Монгол төрөл хэлэнд “хөл” нь хүний доод хоёр мөчийг тусгайлан заах утгатай болсон мөртөөн “хөл (<*kolö)”-өөс гаралтай “гар” гэгч үг нь дээд хоёр мөчийг тусгайлан нэрлэх болсон байна.

Иймээс хүний бие махбодыг нэрлэж байсан “эх, адаг” хэмээх үг нь орчин үед гол мөрөн, хэрэг явдалын эхлэл төгсгөлийг заах зэргээр үндсэн утга гэхээсээ илүүтэйгээр салаа утгаараа хэрэглэгдэж хэвшсэн байхад “толгой, хөл” гэх үгнүүд нь усны урсгалын эхлэл төгсгөл зэргийг илтгэж байснаа бүрмөсөн больж харин хүний бие махбодыг нэрлэх болсон байна.

²³ Я.Цэвэл (2013), Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар, 798-р тал.

Ном зүй:

Баяр (1981), Монголын нууц товчоон, Өвөр монгол.

额尔登泰, 乌云达莱校勘(2006), 蒙古秘史校勘本 [Z].内蒙古人民出版社,

Цэцэнцогт (1988), Монгол үгсийн язуурын толь, Өвөр монгол.

吴双 (2014), 满语人体词语语义研究 [D]. 黑龙江大学.

哈斯巴特尔 (1993), 蒙古语词和朝鲜语词的比较 (上) [J]. 民族语文, 04:10-18.

德力格尔玛 (2006), 波·苏德著.蒙古语族语言概论[M].北京: 中央民族大学出版社.

鲍培著 (2003), 周建奇译.阿尔泰语比较语法[M].呼和浩特: 内蒙古教育出版社.

斯钦朝克图.阿尔泰诸语人体部位名称比较[J] (2004), 民族语文, 02:13-22.

Т.Дашцэдэн (2009), Монголын нууц товчоон эх бичгийн латин галиг, Улаанбаатар.

Өвөрмонголын монгол хэл утга зохиол түүх судлах газар (1979), Хорин нэгт тайлбар толь, Өвөр монгол.

Ш.Чоймаа (2011), Монголын нууц товчоон эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, Улаанбаатар.

Ш.Чоймаа (2007), «Монголын нууц товчоон» хийгээд монгол сурвалж бичгийн судлал, Өвөр монгол.

Я.Цэвэл (2013), Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.

Элдэнтэй, Ардажав (1985), «Монголын нууц товчоон» - сийрүүлэл тайлбар, Өвөр монгол.